

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙ ХҮМҮҮЖИГЧ НАРТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

### PROBLEMS AND SOLUTIONS FOR WOMEN WITH DISABILITIES

**Н.Удвалцэцэг**

Дотоод хэргийн их сургуулийн докторант, хошууч

**Товч агуулга:** Аливаа судалгааны ажил нь нийгэмд тулгамдаад буй тухайлсан асуудалд чиглэж, тодорхой шийдэл, чиг баримжаа гаргахыг зорьж байдаг. Энэхүү илтгэлээр хорих ял шийтгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын эрх зүйн байдалд бодит дүн шинжилгээ хийж, тэдэнд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг зорьлоо.

**Түлхүүр үг:** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн байдал, нийгмийн хамгаалал, боловсролын асуудал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах асуудал, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралд нийгмийн амьдралд тэгш хүртээмжтэй оролцох боломж.

Удиртгал:

Мэдээлэл, технологийн 21 дүгээр зуунд нийгмийн бүхий л салбарт хүний эрхийг хуулиар хангах асуудалд анхаарал хандуулж, судалгаа, шинжилгээний бүтээлийг олон эрдэмтэн, судлаачид бүтээл туурьвиж, нийтийн анхааралд хүрэхийн хирээр төр засгийн болон төрийн бус байгууллагад олон шинэ санаачилгат төсөл, хөтөлбөрүүд зохих төвшинд хийгдэж, энэ чиглэлийн салбар эрчимтэй хөгжиж байна .

Засгийн газар, хариуцсан чиг үүргийн байгууллагын зүгээс хүний эрхийг хангах чиглэлээр олон төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулж, нийгэм олон нийтэд хүрч байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх ажил цаг үеэсээ хоцрогдсон, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр “...ярианы хэлийг дохионы хэлмэрч тайлбарлах, төрийн байгууллага, аж ахуй нэгжийн үүдний хэсэгт налуу шат байрлуулахаас өөр төвшинд хүрээгүй, бодлогын хэмжээнд анхаарал хандуулж, шинжлэх ухааны төвшинд судалж, цаашдын чиг баримжааг тодорхойлох зайлшгүй шаардлагатай...” гэж судлаачийн зүгээс үздэг.

Энэ ч утгаараа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг бүх төвшинд хангах, тэр дундаа “...хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын эрхийг хамгаалах, нийгмийн баталгааг хангах, тэднийг сурч боловсрох, нөхцөл бололцоогоор хангах, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх...” цаг үеийн шаардлага байна гэж үзсэн бөгөөд “...Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч

нарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам...” ерөнхий сэдвийг дараах 3 асуудлын хүрээнд тоймлон авч үзсэн.Үүнд:

1.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдал.;

2.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нараас авсан судалгааны дүн,

3.Дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдал.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь мэргэжлийн олон төрлийн албадыг багтаасан, үйл ажиллагааны чиглэл тус бүр өөрийн өвөрмөц онцлог шинжтэй, 100 гаруй жилийн баялаг түүхтэй байгууллага бөгөөд хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, тогтоолын дагуу “эрүү, иргэн, захиргаа”-ний хэргийн шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн .

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407 дугаар нээлттэй хаалттай хорих анги нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд зааснаар хорих ялыг биечлэн эдлүүлэхээс гадна “...хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хүмүүжигч нарын гэмт санаа бодлыг арилгах, засан төлөвшүүлэх, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, их дээд сургуульд элсэн суралцуулах...” боловсролын байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус хорих анги нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигчийг “...ажлыг байраар хангах, мэргэжил эзэмшүүлэх, нийгмийн баталгааг хангах...” чиглэлээр шат дараатай ажил эхлүүлж, тэдэнд чиглэсэн зорилтот хөтөлбөрийг дэвшүүлж, хорих ангид хуваарилагдаж ирсэний дараа 50-60 хувьд нь “...тогооч, оёдолчин, оёдолын мастер...” зэрэг мэргэжлийг эзэмшүүлж, 80-90 % ажлын байраар хангасан байна.

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдлын эзлэх хувь.

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдлын гэмт хэрэг үйлдсэн тоо, давтамж

Энд дурдсанчлан тус ангийн удирдлагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын “...ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох эрхийг хангах, нийгмийн баталгааг хангах...” хүрээнд “...хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарт хорих ангид ирсэний дараа мэргэжил эзэмшүүлж, ажлын байраар хангаж байгаа ч тэдэнд тохирсон ажлын байр хомс, хөдөлмөр чадвар алдалтын хувь

өндөр, ар гэрийн эргэлт, холбоо байхгүй, суллагдсаны дараа хүлээн авах орчин байхгүй...” зэргээс давтан гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлэх асуудал буурахгүй байгаа нь судлаач миний анхаарлыг ихээхэн татаж байгаа юм.

Хүснэгт 3. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ.

Тус байгууллагад хорих ял эдэлж буй хөдөлмөрийн бэрхшээлтэй хүмүүжигчдийн – 23% нь хөдөлмөрийн чадвараа 50 – 60 алдсан, – 32 % 61 – 70 алдсан, – 45% орчим хувь нь 71 – 80 хувийн алдагдалтай байгаа нь байгууллагын зүгээр ажлын байраар хангасан хэдий ч хөдөлмөрийн алдагдалын хувь хэмжээ их байгаагаас шалтгаалж, ажлын бүтээмж муу байхын зэрэгцээ болзошгүй ажлын осол, эрсдэл гарах магадлал их болохыг илтгэн харуулж байна.

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нараас авсан судалгааны дүнгийн талаар.

407 дугаар нээлттэй хаалттай хорих ангийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүжигч нарт тулгамдаж буй асуудал болон сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүртээмж, хэвийн ажиллагааны талаар судалгаа авсан. Үүнд:

Хорих ял эдэлж буй хөдөлмөрийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигчдийн – 23% нь 20-30 настай, – 32% орчим хувь нь 31 – 40 настай, 46% нь 51 –ээс дээш настай, – 45% нь 41 – 50 настай хоригдлууд байгаа болон дундаас дээш хувийг 51-ээс дээш насныхан эзэлж байгаа нь цаашид насны онцлогоос хамаарч хөдөлмөр алдалтын хувь хэмжээг нэмэгдэж боломжтой байгааг харуулж байна.

Хүснэгт 4. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын насны хэмжээ

Танд хуульд заасан эрхээ эдэлж, үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг нэрлэнэ үү? Гэсэн асуултад суллагдсаны дараа нийгэмд хүлээн авах орчин байхгүй –50%, өөрт тохирсон ажил байхгүй –40%, бусадтай ойлголцоход хүндрэлтэй байдаг –10% гэсэн хариултыг тус тус сонгосон байна.

Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарт тулгамдаж буй асуудлуудын дараалал.

Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник хэрэгслийн хүртээмж хангалттай түвшинд байдаг уу? гэсэн асуултад хүртээмж муутай, нэмэгдүүлэх шаардлагатай – 80 хувь, хэвийн хүрэлцээтэй байдаг – 10, үлдсэн 10 хувь нь тодорхой хариулж мэдэхгүй байна гэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд нь чанарын шаардлагад нийцэж байгаа эсэх? Гэсэн асуултад 70.0

хувь нь чанарын шаардалагад нийцдэггүй, үзүүлэлт муутай, 18.0 хувь нь техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, үзүүлэлт муу, 12.0 хувь тодорхой үнэлгээ өгөх боломжгүй гэсэн хариултыг тус тус сонгосон байна.

Хүснэгт 6. Сургалт, нөлөөллийн ажилд ашиглаж буй техник хэрэгслийн чанар, хүртээмжид хийсэн сэтгэл ханамжийн судалгаа.

Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник, хэрэгслийн ажиллагаанд сэтгэл ханамж ямар түвшинд байдаг вэ? гэсэн асуултад 81 хувь нь сэтгэл ханамж муу, хоцрогдсон, шинэчлэх шаардлагатай 10 хувь нь хэвийн ажиллагаатай, техникийн шаардагд нийцсэн гэсэн бол үлдсэн 9.0 хувь нь тус байгууллагын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд тодорхой үнэлгээ өгөөгүй гэсэн дүн судалгаа гарсан байна.

Гурав. Дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тэр дундаа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь “...анх хуваарилагдан ирэхдээ эзэмшсэн мэргэжилгүй байсан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарыг 50-60 хувьд мэргэжил эзэмшүүлсэн, 100 хувь ажлыг байраар хангаж, тогтоосон хэмжээгээр цалин олгож, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж байгаа...” зэргээс Монгол Улсын Үндсэн хуульд заасан “...сурч боловсрох, ажиллах, хөдөлмөрлөх...”-ийг бүрэн хангаж, хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн гэж үзэж болохоор байна.

Гагцхүү хорих ял эдлүүлэх байгууллагад хангагдаж буй хүний хуулиар хязгаарлаагүй “...сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, ялгаварлан гадуурхахгүй байх...” зарим эрхүүд эрх чөлөөт нийгмийн амьралд бүрэн хангагдаж чадахгүй байгаа нь “...хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нар суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэх тохиолдол буурахгүй байгаа, нийгэмд тохирсон ажлыг байр олдохгүй байх, бусадтай ойлголцоход хүндрэлтэй байдаг...” зэргээс тодорхой харагдаж байна.

Монгол улсын эдийн засгийн тогтворгүй байдал, сүүлийн жилүүдэд хурдацтай өссөөр байгаа инфляцийн төвшин, төсвийн таналт, батлагдсан төсөв хүрэлцдэггүй зэрэг санхүүгийн хүчин зүйлээс хамаарсан “хүндрэл, бэрхшээл” бүхий л төрийн байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж байгаатай адил 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид ч мөн тулгамдаж байна.

Дээр дурдсан санхүүгийн хүчин зүйлээс үүсэн асуудал болон “...эмэгтэй хүмүүжигч нарын сурч боловсрох, хөдөлмөрлөх, ар гэртэйгээ байнгын цахимаар харилцаа, холбоотой байх, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдогч нарын сургалт, боловсролын үйл ажиллагаанд ашиглах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн “...хүрэлцээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах...” цаг үеийн шаардлага байгаа бөгөөд энэ ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэг, туслалцаа нэн чухал шаардлагатай болоод байна.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, санал

- Хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх, энэ чиглэлийн ажлыг олон нийтэд хүргэх, сурталчилах;

- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигчийн сулагдсаны дараа нийгэмд дасгах, ажил олгогчид зуучлах, ажлын байраар хангах асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газартай хамтран шийдвэрлэх;

- Хөгжлийн бэрхшээлтэй хорих ял шийтгүүлсэн хүмүүжигчийг сурч боловсрох эрхийг хангах хүрээнд сургалтын үйл ажиллагаанл ашиглаж буй тоног төхөөрөмжийг хүрэлцээг сайжруулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газар хооронд хамтран ажиллах санамж бичиг боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигчийн эрхийг хангах бодлогын баримт бичиг боловсруулах, төсөл, хөтөлбөрүүдэд энэ талаар тусгах.